БАТЛАВ.
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ Ч.БАТ-ЭРДЭНЭ

## ХӨЛСӨӨР АЖИЛЛУУЛАХ ГЭРЭЭ

2016 оны 11 сарын 04-ны өдөр

№ 20161104046 Улаанбаатар хот

Нэг талаас захиалагч Эрүүл мэндийн хөгжлийн төв / цаашид "захиалагч гэх/-ийг төлөөлж Захиргаа, аж ахуйн албаны дарга Л.Оюунчимэг, нөгөө талаас ХЙ62062977 тоот регистерийн дугаартай Чингэлтэй дүүргийн 14 хороо хайлааст 9 гудамж 112 тоотод оршин суугч иргэн Баасан овогтой Оргил / цаашид "Хөлсөөр ажиллагч"гэх/ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

### 1. Нийтлэг үндэслэл

1.1.Захиалагч, хөлсөөр ажиллагч нар захиалгат ажлыг гүйцэтгэх, эрх тэгш байх, харилцан ашигтай байх зарчмыг баримтлан ажиллана.
1.2.Энэхүү гэрээнд зааснаас бусад тохиолдолд ажил гүйцэтгэх үйл ажиллагааг Монгол Улсын Иргэний хуулийн 359-369 дүгээр зүйлийг баримтлан явуулна.
1.3. Хөлсөөр ажиллагч нь Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захиалгаар дуудлагын слесарийн ажлын байрны тодорхойлолтонд заасан ажил, үүргийг гүйцэтгэнэ.
1.4. Хөлсөөр ажиллагч нь байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасан ажлын цагийн горимыг баримтлан ажиллана.
1.5. Энэхүү гэрээ нь 2016 оны 11 сарын 04-нээс эхлэн Д.Энхтөрийг ажилдаа эргэн орох хүртэл хугацаанд хүчинтэй. Талууд харилцан тохиролцож гэрээний хугацааг сунгаж болно.

### 2. Захиалагчийн хүлээх эрх, үүрэг

2.1. Хөлсөөр ажиллагч иргэн Б.Оргил-аар шаардлагатай үед слесарийн ажил, үүрэг гүйцэтгүүлнэ.
2.2. Слесарийн ажил (үүрэг)-ийг гүйцэтгүүлэхийн тулд холбогдох материал, хэрэгслээр хангана.
2.3. Слесарийн ажил гүйцэтгүүлэхийн тулд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хөдөлмөрийн нөхцөлөөр хангана.
2.4. Ажил олгогч нь ажилтанд Засгийн газрын 2007 оны 354, 2014 оны 75 дугаар тогтоолын дагуу төрийн үйлчилгээний мэргэжлийн албан хаагчийн ТҮ-3 зэрэглэлийн 1 дэх шатлалын сарын үндсэн цалингийн хэмжээ: **419,556** /дөрвөн зуун арван есөн мянга таван зуун тавин зургаан / төгрөгийн цалин, бохирын нэмэгдлийг албан тушаалын цалингийн 40%-иар тооцож олгохоор тохиролцов.

2.5. Хөлсөөр ажиллагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь төлнө.

ажлыг гүйцэтгэх боломжгүй тохиолдолд захиалагч талд урьдчилан мэдэгдэж тохиролцон, шаардлагатай гэж үзвэл ажлыг гүйцэтгэхээс татгалзах эрхтэй.
3.6. Гэрээнд заасан цалин хөлсийг гүйцэтгэлийн дагуу хугацаандаа өгөхийг шаардах эрхтэй.

## 4. Гэрээг дүгнэх, бусад

4.1. Гэрээт ажил үүргээ биелүүлж, холбогдох ажилтан, албан хаагч нарт тайлан тооцоогоо бүрэн гарган өгч, хянуулснаар гэрээг дүгнэнэ.
4.2. Гэрээний хэрэгжилтийг Захиргаа, аж ахуйн албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч, аж ахуйн менежер нар дүгнэнэ.
4.3. Энэхүү гэрээтэй холбоотой маргааныг эв зүйгээр зохицуулж, тохиролцоогүй тохиолдолд шүүхэд хандаж шийдвэрлүүлж болно.
4.4. Аль нэг талын буруутай үйл ажиллагааны улмаас гарсан зардлыг буруутай тал нь нөхөн төлнө.
4.5. Гэрээг хоёр хувь үйлдэн, гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний эх хувиуд адил хүчинтэй байна.
4.6. Хоёр тал харилцан тохиролцож энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Зөвхөн бичгээр үйлдсэн гэрээний нэмэлт өөрчлөлтүүдийг хүчинтэйд тооцож, энэхүү гэрээний салшгүй хэсэг болгон баталгаажуулна.

## 5. Талуудын хаяг

**Захиалагч:**

Нэр, албан тушаал : В. Оюунчимэг
ЗААА-ны дарга

Утас:

Гарын үсэг: [signature]

**Хөлсөөр ажиллагч:**

Нэр, Хаяг: Чингэлтэй дүүрэг
Жайлстион 9-112 тоот

Утас:

Гарын үсэг: Б. Оргил